



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/340

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2020 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Адарга сумын нутаг дэвсгэрт “Их барчгайт” нэртэй газарт 203.57 га талбайд “Күүпермен” ХХК -д Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олсугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Нямхатан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Баян-Адарга сумын Засаг дарга /О.Лхагвадорж/-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Хайгуулын ажлын төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан батлуулж, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Күүпермен” ХХК-д зөвлөсүгэй.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Нямхатан/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

